



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/222

Мандалговь

Малын сэг зэм устгал, халдваргүйтгэлийн
сарын аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны А/34 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийн устгал, урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сарын 15-ний өдрөөс эхлэн аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Малын гоц халдварт өвчин, салхи шуурганы үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг малын өвчин тархах, байгаль орчин бохирдуулахаас сэргийлж хороо, бууц, худаг уст цэг, бэлчээр, авто замын дагуу болон төв суурин газрын орчмоос цуглуулж, зориулалтын цэгт булж, устгах халдваргүйтгэх арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор шуурхай зохион байгуулж, дүн мэдээг Мал эмнэлгийн газарт мэдээлж ажиллахыг бүх сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх болон зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, байгаль орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийн ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллан, дүн мэдээг нэгтгэн танилцуулахыг Мал эмнэлгийн газар (И.Жавхлант), Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР



48 3100586